

## ДЭЛХИЙН НИЙГМИЙН НЭРТ СЭТГЭГЧИЙН НОМЫН ТУХАЙ

### Танилцуулга № 1.

(Олвин Тоффлер. Хүчний шилжилт)  
612 хуудастай.

О. Тоффлер орчин үеийн дэлхийн нийгмийн нэрт сэтгэгчийн нэг бөгөөд «Ирээдүйн дайрлага», «Гуравдугаар долгион», «Хүчний шилжилт» гэдэг гурвал ном зэрэг дэлхийн 50 гаруй оронд орчуулагдан олон сая хувнар нийтлэгдсэн маш их гүйлгээтэй зохиол туурвижээ. «Гуравдугаар долгион» нь Дэн Сяопинийн зохиолын дараа орох олон хувиар Хятадад нийтлэгдэн хятадын шинэчлэлийн сэхээтний «библи» (өврийн ном) болжээ. Хятадын ерөнхий сайд Чжао Цзыян түүний номын тухай бага хурал хийгээд, уг зохиолыг судлахыг улстөрийн зүтгэлтнүүдэд даалгасан байна. Түүний зохиолууд дэлхий даяар маш их сонирхогдож байгаа нь илт байна.

Түүний гурвал ном 1950-аад оны дунд үеэс барагцаалбал 2025 оныг дуустлах үеийг хамарч байна. Олон зуун жил үргэлжилсэн аж үйлдвэрийн иргэншлийн үе энэ хугацаанд дуусч дэлхийг донсолгосон хүчний тэмцлийн огт өөр үеэр солигдоно. Гурван ном хоорондоо ялгаатай.

1970 онд АНУ-д анх нийтлэгдсэн «Ирээдүйн дайрлага» номд өөрчлөлтийн процесс хэрхэн явагдаж, хүмүүс, байгууллагад яаж нөлөөлж байгааг харуулжээ. 1980 онд хэвлэгдсэн «Гуравдугаар долгион» зохиолд өөрчлөлт хүмүүсийг хааш нь хөтлөн явж байгаа чиглэлийн тухай өгүүлсэн юм. 1990 онд гарсан «Хүчний шилжилт» номд өөрчлөлтийг хэн яаж бүрэлдүүлэх гэж байгаа хяналтын тухай өгүүлжээ.

«Хүчний шилжилт» бол XXI зууны зааг дахь хүчний тухай ном юм. Хүч гэж юу бэ? Хүч бол хүчирхийлэл (хар хүч), баялаг (мөнгө, хөрөнгө), мэдлэг (эрдэм) энэ гурав мөн. Ингэхлээр энэ гурван төрлийн хүч бол хэт том зах зээл, банк, төр, захиргааны байгууллага, сүм хийд, сургууль, эмнэлгийн газар, айл өрхийн дотор, ер нь хаа сайгүй үйлчилж байдаг байна. Одоо хүч хүний нийгмийн системийн бүх түвшинд улам бүр эрчимтэйгээр бүхнийг хамран өөрчлөгдөн шилжсээр байна. Ингээд хүчний мөн чанарт хувьсгал гарах гэж байна.

О. Тоффлер зохиолоо туурвихдаа дэлхийн эрт, эдүгээгийн суут сэтгэгчдийн бүтээлийг өргөн ашиглахын зэрэгцээ Михайл Горбачев, Рональд Рейган, Жорж Буш, Японы ерөнхий сайд, тэр ч байтугай ЗХУ-ын Коммунист Намын Төв Хорооны Улс төрийн Товчооны гишүүн Анатолий Лукьяновтай уулзсанаас гадны банкны эзэд, ажилчны үйлдвэрчний эвлэлийнхэн, бизнесийн толгойлогчид, компьютерийн мэргэжилтэн нар, генералууд, нобелийн шагналтан эрдэмтэд, нефтийн том эзэд, сэтгүүлчид, дэлхийн хамгийн том компаниудын олон том менежертэй уулзан, ярилцаж зөвлөлджээ. Тэд (О. Тоффлерийн гэргий түүнтэй хамтран ажилладаг номын хамтран зохиогч мөн боловч, нэрээ зохиогчоор тавиулдаггүй байна) манай дэлхий дээрхи хамгийн хүч үгүй хүмүүст тооцогдох Өмнөд Америкийн «ядуучуудын хот»-ын

оршин суугчид, мөн насаараа хоригдох ялтан эмэгтэйчүүдтэй уулзжээ. Бодит хүч ил байдаг шоронг бид очиж үзсэн гэж О. Тоффлер бичиж байна. О. Тоффлер хүч гэдэг чухам юу яаж шилжин өөрчлөгддөг, ирээдүйд ямар болох гэж байгааг онолын сэтгэхүй, амьдралын үнэн байдалд тулгуурлан бичжээ.

Энэ ном 6 анги, 34 бүлэгтэй. Үүнд:

1-р анги. Хүчний утга учир: 1—20-р тал.

2-р анги. Хэт бэлэгдлийн эдийн засгийн үеийн амьдрал: 23—28-р тал.

3-р анги. Мэдээллийн дайнууд: 91—157-р тал.

4-р анги. Уян фирм дэх хүч: 161—234-р тал.

5-р анги. Хүчний шилжилтийн бодлого: 237—379-р тал.

6-р анги. Дэлхийн хэмжээний хүчний шилжилт: 383—551-р тал.

Ном зүй, тайлбар, хэлхээстэй.

О. Тоффлер 1-р ангийн эхний хуудасны нүүрэнд «Бууны амнаас хүч гардаг» гэсэн Мао Цзэдуны үг, «Мөнгө ярьдаг» гэсэн яриа, «Мэдлэг бол хүч мөн» гэсэн Фрэнсис Бэконы үгийг ишлэл болгожээ. Мао Цзэдун хүчирхийллийг гол болгож байхад, хүмүүс хөрөнгө мөнгийг голлон, Ф. Бэкон эрдмийг чухалчилж байна. Энэ гурван хүч түүхийн янз бүрийн үед нийгмийн амьдралын янз бүрийн салбарт янз янзаар загвар буюу хослон хэрэглэгдсээр иржээ. Эртний нийгэмд гол төлөв хүчирхийлэл хэрэглэгдэж байсан бол феодализмд хүчирхийлэл, баялаг хоёр голлож байв. Капитализмын үед хүчирхийлэл, баялгийн зэрэгцээ мэдлэгийг их чухалчлах болжээ. Орчин үеийн зах зээлийн харилцаанд мэдлэг (техник, технологи) тэргүүлэн, баялаг, (мөнгө) дагалдахын хамт хүчирхийлэл гол төлөв далдуур хэрэглэгдэж байна.

Хүчний шилжилт нь орчин үе, ирээдүйд хүний санаанд оромгүй хэлбэр, агуулга, цартай болж байна, болсоор байна, болох гэж байна.

О. Тоффлерийн «Хүчний шилжилт» номын агуулгыг ойлгомжтой болгохын тул номынхоо шувтарганд дүгнэлт болгосон бодлыг урьдчилан танилцуулъя. Үүнд:

1. Хүч бол бүх нийгмийн систем, бүх хүчний харилцааны мөн чанар болсон зүйл мөн бөгөөд эд юм биш, харин аливаа бүх хүний харилцааны тал юм. Иймд зайлшгүй байх саармаг зүйл, уг чанартаа сайн ч биш, муу ч биш юм.

2. «Хүчний систем»-хүн бүрийг хамарна, хэн ч түүнээс ангид байдаггүй, гэвч нэг хүний хүчний алдагдал дандаа нөгөө хүний хожоо болдоггүй юм.

3. Аливаа нийгмийн хүчний систем нь нэг нь нөгөөдөө үүрлэсэн жижиг жижиг хүчний дэд системүүд юм. Шууд, урвуу холбоос эдгээр дэд системийг хооронд нь, мөн тэдгээрээс бүрддэг том системтэй холбодог. Тус тус хүмүүс янз янзын гэхдээ уялдаатай хүчний дэд системүүдэд хамаарагддаг.

4. Нэг хүн гэртээ хүч ихтэй, ажил дээрээ, эсхүл өөр талаар хүч багатай байж болно.

5. Хүмүүсийн хоорондын харилцаа байнга өөрчлөгдөж байдаг учир хүчний харьцаа мөн байнгын процесс байдаг.

6. Хүмүүс хэрэгцээ, хүсэл эрмэлзэлтэй байдаг, түүнийгээ биелүүлж чадвал хүчний нөөцтэй байгаа гэсэн хэрэг юм. Нийгмийн хүч бол хүсүүштэй буюу шаардлагатай зүйлс, ажлаар хэрэгждэг байна.

7. Хүмүүсийн хэрэгцээ, хүсэл эрмэлзлэл маш олон янз байдаг учир тэдгээрийг биелүүлэх, эс биелүүлэх арга хэрэгсэл мөн асар олон янз байдаг. Энэ талаархи хүчний «түвшин», «багаж» олон янз байдаг боловч хүчирхийлэл, баялаг, мэдлэг нь анхдагч байдаг.

8. Ихэвчлэн залхаахад хэрэглэгддэг хүчирхийлэл бол хүчний хамгийн өрөөсгөл эх булаг мөн. Залхаах, урамшуулахын аль алинд хэрэглэгддэг, тэрчлэн олон янзын арга хэрэгсэл болгон ашиглаж болдог баялаг бол хүчний нэлээд их уян багаж мөн. Мэдлэг хамгийн олон талтай гол хэрэгсэл мөн. Мэдлэг хамгийн дээд зэргийн хүчийг бий болгодог.

9. Анги, үндэстэн, ястан, мэргэжил зэрэг нийгмийн олон бүлэг нь хүн ам, экологи, технологи, соёл мэтийн хүчин зүйлд шилжилт (өөрчлөлт) гарахаар байнга өөрчлөгдсөөр байдаг. Эдгээр өөрчлөлтийн улмаас зөрчил гарч, хүчний эх булгийг дахин хуваарилах болгодог.

10. Зөрчил бол нийгмийн зайлшгүй хүчин зүйл мөн.

11. Хүчний тэмцэл заавал муу байх албагүй юм.

12. Янз бүрийн дэд систем хүчний шилжилт нэгэн зэрэг болох юм бол тэдгээр дэд системээс бүрддэг том системийг эрс тэсээр өөрчилж болно. Энэ зарчим бүх түвшинд үйлчилдэг. Бие хүний дотоод сэтгэцийн зөрчил нь бүтэн гэр бүлийг бусниулж болно. Салбаруудын хоорондын зөрчил нь бүтэн компанийг задлаж болно. Мужуудын хоорондын зөрчил нь нэг улсыг бутаргаж болно.

13. Том системийг бүрдүүлэгч хүчний олон системийн зарим нь нэг үед харьцангуй тэнцвэртэй байхад бусад нь нэлээд тэнцвэргүй байж болно. Тэнцвэр заавал сайн зүйл байх албагүй.

14. Хүчний системүүд нэлээд тэнцвэргүй байж байхад гэнэт хачин шилжилт гарч болно. Учир нь систем буюу дэд систем их тогтворгүй байхад шулуун биш үр дагавар ихэсдэг. Том хүчний нөлөө бага үр дагавартай байж болно. Жижиг явдал бүтэн байгууллыг унагаж болно. Хоолны давс таараагүйгээс болоод гэр бүл салж болно.

15. Тохiolдлын зүйлс байдаг. Уг систем тогтворгүй байх тусам тохиолдлын зүйл төдийчинээ их байх болно.

16. Хүч тэнцүү байх нь байж болшгүй зүйл мөн бөгөөд байлаа ч гэсэн тохиолдлоор тэнцүү биш байдал даруй бий болж, урьдын тэнцүү биш байдлыг засах гэж оролдох болно.

17. Нэг түвшний тэнцүү биш байдлыг нөгөө түвшин дээр тэнцвэртэй болгож болно.

18. Нийгмийн бүх систем, дэд систем нэгэн зэрэг бүрэн тэнцвэртэй байх, мөн нийгмийн бүх бүлгийн хооронд хүчийг тэнцүүхэн хуваарилсан байх боломж үнэн хэрэг дээрээ байх аргагүй юм. Дарлагч байгууллыг түлхэн унагаахад эрс шийдэмгий ажиглагаа хэрэгтэй байж болох боловч зарим талаар тэнцүү биш байх нь уг өөрчлөлтийн функц юм.

19. Бүрэн тэнцүү байвал өөрчлөлт гарахгүй байж болно. Ийм байдал байх боломжгүйгээр барахгүй, хүсүүштэй зүйл биш юм. Сая саяараа өлсч байгаа дэлхий дээр өөрчлөлт гаргахгүй байх үзэл бол ёсон бусын зүйл мөнөөр барахгүй ёс суртахуунгүй зүйл юм. Иймд ямар нэг хэмжээний тэнцүү биш байдал байх нь угтаа ёс суртахуунгүй зүйл биш юм. Юу ёс суртахуунгүй байх вэ? гэвэл хүчний эх булаг болдог зүйлсийг буруу хуваарилсныг хэвээр байлгадаг байгуулал юм. Тэр буруу хувиарлалт нь арьс, үндэстэн зэрэг зүй ёсны зүйл дээр үндэслэсэн байвал тэр нь бүр давхар ёс суртахуунгүй зүйл болно.

20. Мэдлэг бол зэвсэглэл, баялагаас илүү буруу хуваарилагджээ. Мэдлэгийг (ялангуяа мэдлэгийн тухай мэдлэгийг) дахин хувиарлах

нь чухал ач холбогдолтой бөгөөд хүчний бусад гол эх булгийг дахин хуваарилахад хүргэнэ.

21. Хүчний эх булгийг хэт төвлөрүүлэх нь аюултай. Сталин, Гитлер зэрэг олон жишээ дурдаж болно.

22. Хүчний эх булгийг дутуу төвлөрүүлэх нь бас аюултай. Ливанд хүчтэй засгийн газар байхгүй байсан нь энэ ядуу ард түмнийг эмх замбараагүй хүчирхийлэлтэй адил юманд оруулаад байна. Хориод бүлэг хүмүүс ямар нэг хууль, шударга ёс баримтлахгүйгээр хоорондоо засгийн эрхийн төлөө тэмцэлдсээр байна.

23. Хүчний хэт төвлөрөлт, дутуу төвлөрөлтийн аль алин нь нийгэмд гай гамшиг учруулна. Ингэхлээр ёс суртахууны ямар үндэс байх вэ? Хүч хэт төвлөрсөн, эсхүл дутуу төвлөрсөн байгаа эсэх нь «нийгмийн зайлшгүй чухал эрх мэдэл», «хэт эрх мэдэл», энэ хоёроор тодорхойлогдоно.

24. Гаднын жинхэнэ бодитой аюул заналаас хамгаалж чадахын зэрэгцээгээр дотоодын хэв журам, иргэний ёс дэглэмийг байлгаж чадах хэмжээгээр хүч (засаг, төрийн эрх мэдэл) төвлөрөх нь нийгмийн хувьд зайлшгүй чухал байх учир ёс суртахууны хувьд шударга зүйл болно. Иргэний нийгэм оршин тогтноход шаардагдах хэмжээнээс илүү буюу хэтрүүлэн эдлэсэн эрх мэдэл бол ёс суртахуунгүй явдал мөн.

25. «Хэт эрх мэдэл»-ийг эдлэсэн төрийг эсэргүүцэх буюу түлхэн унагаах нь ёс суртахууны үндэстэй юм.

Сэтгүүлийн дараагийн дугаарт бусад бүлгээс нь танилцуулах болно

доктор Г. СУХБААТАР